

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН
2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
НЭГДҮГЭЭР ОРЛОГЧООС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР /№19/

2021 оны 11 дүгээр сарын 30

Улаанбаатар хот

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах хэлтэс, албад	Хяналт тавих албан тушаалтан
1	Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тархалтыг бууруулах ажлын хүрээнд албан хаагчдаа дархлаажуулалтын нэмэлт тунд идэвхтэй хамруулах, нэмэлт тунд хамрагдаагүй албан хаагчдын нэр, тайлбарыг тодорхой гаргаж, дүүргийн Засаг даргын Тамгын газарт албан бичгээр хүргүүлэх	Нийгмийн хөгжлийн хэлтэс, нийт байгууллага	Засаг даргын Нэгдүгээр орлогч Б.Цэрэн
2	Халтиргаа гулгаанаас сэргийлж нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, алслагдсан хороолол авто зам болон орон сууцны хороолол доторх авто замын цас цэвэрлэгээний ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах.	Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтэс, “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ, “Хан-Уул зам засвар, арчлалт” ОНӨААТҮГ	Засаг даргын орлогч С.Сайнбаяр
3	Дүүргийн Цагдаагийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1 сарын аян зохион байгуулах, хэлтэс, албад тодорхой арга хэмжээ авч ажиллах	Цагдаагийн газар, нийт байгууллага	Засаг даргын Нэгдүгээр орлогч Б.Цэрэн
4	Аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан “Хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилтэд хяналт тавих хамтарсан багийн хяналт шалгалтыг эрчимжүүлэх, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс	Засаг даргын орлогч А.Амартүвшин
5	Төсвийн тухай хуулийн дагуу хэлтэс, албад 2022 оны төсөвт тусгах саналаа гаргаж, албан бичгээр дүүргийн Засаг даргад хандаж ирүүлэх	Санхүү төрийн сангийн хэлтэс, нийт байгууллага	Засаг даргын орлогч С.Сайнбаяр

Жич: Үүрэг даалгаврын биелэлтийг 2021.12.06-ны өдрийн 12:00 цагаас өмнө /khanuul.1208@gmail.com/
цахим хаягаар хүлээн авна

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ

Б.ЦЭРЭН

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Б.АРИУНАА